

УЛС ТӨРИЙН ТОВЧООНЫ ГИШҮҮДИЙН ХЭВ МАЯГ, СОЦИАЛ ТӨРХ
(1940-1990 он)

Ч.Тамир

докторант

(МУИС, Социологи-нийгмийн ажлын тэнхим)

(“XX зууны Монголчуудын улс төрийн оролцоо” сэдэвт судалгааны ажлын хүрээнд энэхүү өгүүлэл нь хэвлэгдэж байгаа болно)

1.Элитүүдийн ангилал

Америкийн судлаач Миллс америкийн нийгмийн амьдралыг улс төр, эдийн засаг, цэргийн хүрээнд төвлөрлийн үйл явц болсон гэж нотолдог [1]. Дээрх гурван бүлгийн төлөөлөгчид нь засаглалын нарийн систем болон бүрэлдэж, голдуу нийгмийн нэг орчноос гаралтай, адилхан үзэл бодолтой, нийтлэг ашиг сонирхолтой байхаас гадна бие биетэйгээ танил байх нь цөөнгүй [11]. Гэвч тэрээр нээлттэй ардчилсан нийгэм дэх элитийн тухай ярьж байна. Манай нэрт социологич Х.Гүндсамбуу номенклатурчдын бүтцийг намын, төрийн, техникийн хүнд сурталтнууд гэж гурав хуваан үзсэн нь бий [12].

Доорх судалгаанд УТТ гишүүн, орлогч, намын ба төрийн бусад дээд албан тушаалыг хэрхэн хавсарч хашиж байсан, мөн хэдэн удаа сонгогдсон гэдгийг ч гэсэн харуулав⁴⁶.

| | Улс төрийн товчооны гишүүний нэр | УТТ гишүүн ⁴⁷ | Ерөнхий НБД | II НБД | НБД-г хавсарсан | НХШХ | УТТ орлогчоор сонгогдож ажиллаж эхлэх үедээ эрхэлж байсан албан тушаал ⁴⁸ | УТТ орлогчоор хавсран ажиллаж байсан дээд тушаал ⁴⁹ |
|----|----------------------------------|--------------------------|-------------|--------|-----------------|------|--|--|
| 1 | Х.Чойбалсан | 1 | 0 | 0 | 0 | 0 | ДЯЯ, ЦЯ-ны сайд | Ерөнхий сайд |
| 2 | Ю.Цэдэнбал | 9 | 7 | 0 | 0 | 0 | СнЗ дарга | АИХ, тэргүүлэгчдийн дарга |
| 3 | Г.Бумцэнд | 2 | 0 | 0 | 0 | 0 | УБХТД | МАХ-ын ТД |
| 4 | Ч.Сүрэнжав | 2 | 0 | 1 | 0 | 1 | МаТар/Яам сайд | Ер сайдын орлогч |
| 5 | С.Янжмаа | 2 | 0 | 0 | 1 | 0 | УБХ-ын орлогч др | - |
| 6 | Д.Дамба | 4 | 2 | 1 | 0 | 0 | УИХ-дарга | - |
| 7 | Б.Дамдин | 2 | 0 | 0 | 2 | 0 | - | - |
| 8 | Ц.Дүгэрсүрэн | 6 | 0 | 1 | 5 | 0 | Аж үйлд/Яамсайд | СнЗ орлогч дарга |
| 9 | Н.Лхамсүрэн | 1 | 0 | 0 | 1 | 0 | - | - |
| 10 | Ж.Самбуу | 6 | 0 | 0 | 0 | 0 | - | АИХ-ын тэргүүлэгч дарга |
| 11 | Б.Ширэндэв | 1 | 0 | 0 | 1 | 0 | Ар-Гэгээрл яамны сайд | Ерөнхий сайдын орлогч |
| 12 | Б.Балжинням | 3 | 0 | 0 | 1 | 0 | МҮЭ төв зөвлөлийн дарга | АИХ, тэргүүлэгч-орлогч др |
| 13 | Д.Ламчин | 1 | 0 | 0 | 0 | 0 | УБ-намын хороон дарга | - |

⁴⁶ Зөвхөн УТТ гишүүн ба орлогч гишүүнээр ажиллаж байх ёдээ хавсарч ажиллаж байсан албан тушаалыг л оруулсан болно.

⁴⁷ УТТ-ын гишүүн ба орлогчийг нэг тэмдэглэгээгээр тэмдэглэсэн болно. 1940 онд сонгогдсон тэргүүлэгчдийг УТТ-тай адилтгах албан тушаал гэж иэж тооцоололд оруулсан болно. Мөн их хурлаас сонгогдсон, НТХ-ны бигд хурлаас УТТ гишүүнээр сонгогдсон аль алиныг нь тооцоонд оруулсан болно. Харин хугацааг харгалзаагүй.

⁴⁸ Юуны өмнө энэ тооцоо бүрэн төгс биш гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Үүнд зохиогч түүхч Ч.Болдбаатарын номыг бүхэлд нь ашигласан болно.

⁴⁹ Улс төрийн товчооны гишүүн орлогчоор ажиллаж байх үедээ хашиж байсан хамгийн өндөр албан тушаалыг оруулсан болно. Үүн дээр тулгуурлан дараагийн ангиллыг хийв.

ПОЛИТОЛОГИ IV
Эрдэм шинжилгээний бичиг № 297 (50)

| | | | | | | | | |
|----|---------------------------|--------|---|---|---|---|---|---------------------------|
| 14 | Л.Цэнд | 3 | 0 | 1 | 0 | 0 | - | Ерөнхий сайдын 1-р орлогч |
| 15 | Д.Моломжамц | 7 | 0 | 0 | 6 | 0 | - | - |
| 16 | Н.Жагварал | 5 | 0 | 0 | 4 | 0 | - | - |
| 17 | С.Лувсан | 3 | 0 | 0 | 0 | 0 | СнЗ-ын 1-р орлогч | АИХ, тэргүүлэгч-ор/др |
| 18 | Д.Майдар | 5 | 0 | 0 | 0 | 0 | СнЗ-ын орлогч дарга | СнЗ-ын 1-р орлогч |
| 19 | Ж.Батмөнх | 4 | 2 | 0 | 0 | 0 | Ерөнхий сайд | АИХ, тэргүүлэгчдийн дарга |
| 20 | Д.Содном | 1 | 0 | 0 | 0 | 0 | СнЗ-ын орлогч дарга | СнЗ-ын дарга |
| 21 | С.Жалан-Аажав | 3 | 0 | 0 | 3 | 0 | - | АИХ, тэргүүлэгч-ор/др |
| 22 | Н.Лувсанравдан | 1 | 0 | 0 | 0 | 1 | - | АИХ, тэргүүлэгч-ор/др |
| 23 | Т.Рагчаа | 3 | 0 | 0 | 0 | 0 | СнЗ-ын 1-р орлогч | - |
| 24 | Б.Алтангэрэл | 2 | 0 | 0 | 0 | 0 | АИХ, тэргүүлэгчд-н дарга, УБХ-ын НХ-дарга | Ерөнхий сайдын орлогч |
| 25 | Д.Гомбожав | 1 | 0 | 0 | 1 | 0 | - | - |
| 26 | Б.Дэжид | 2 | 0 | 0 | 1 | 1 | - | - |
| 27 | Ц.Намсрай | 2 | 0 | 0 | 2 | 0 | - | - |
| 28 | Д.Төмөр-Очир, | 2 | 0 | 0 | 1 | 0 | Намын түүхийн институт, | - |
| 29 | Б.Жамбалдорж, | 1 | 0 | 0 | 0 | 0 | Ерөнхий прокурор | Хянан байцаах яамны сайд |
| 30 | Б.Ламжав, | 1 | 0 | 0 | 0 | 1 | - | - |
| 31 | П.Дамдин | 1 | 0 | 0 | 1 | 0 | - | - |
| 32 | Д.Доржпүрэв | 1 | 0 | 0 | 0 | 0 | Ерөнхий сайдын 1-р орлогч | Шүүх яамны сайд |
| 33 | Ж.Лхагвасүрэн | 1 | 0 | 0 | 0 | 0 | Цэргийн Яамны жинхэнэ орлогч сайд | - |
| 34 | Ё.Магсар | Орлогч | 0 | 0 | 0 | 0 | МХЗЭ-ийн дарга | - |
| 35 | С.Чойжамц | Орлогч | 0 | 0 | + | 0 | - | - |
| 36 | С.Балган | Орлогч | 0 | 0 | 0 | 0 | ХААЯ-ны орлогч сайд | - |
| 37 | Б.Лхамсүрэн | Орлогч | 0 | 0 | + | 0 | - | - |
| 38 | С.Сосорбарам | Орлогч | 0 | 0 | + | 0 | - | - |
| 39 | Д.Цэдэв | Орлогч | 0 | 0 | 0 | 0 | АИХ, тэргүүлэгч-ор/др | - |
| 40 | Ч.Аварзэд | Орлогч | 0 | 0 | 0 | 0 | СнЗ-ийн орлогч дарга | - |
| 41 | Д.Самдан | Орлогч | 0 | 0 | + | 0 | - | - |
| 42 | С.Лувсангомбо | Орлогч | 0 | 0 | 0 | 0 | НАХЯ-ны сайд | - |
| 43 | П.Жасрай | Орлогч | 0 | 0 | 0 | 0 | СнЗ-ын 1-р орлогч | - |
| 44 | Л.Лантуу | Орлогч | 0 | 0 | 0 | 0 | УБ-намын хороон дарга | - |
| 45 | Д.Адьяа НБД ⁵⁰ | 0 | 0 | 0 | + | 0 | - | - |
| 46 | М.Даш НБД | 0 | 0 | 0 | + | 0 | - | - |
| 47 | Ц.Балхаажав | 0 | 0 | 0 | + | 0 | - | - |

Харин бид өөрсдийн судалгааны материал дээрээ тулгуурлан *нэгдүгээрт* партократууд буюу монголын УТТ гишүүн ба орлогч нарыг, *хоёрдугаарт* парто-технократууд засгийн газрын албан тушаалыг хашиж байсан хүмүүсийг, *гуравдугаарт* парто-демократууд гэсэн гурван үндсэн бүлэгт хуваан ангилав. Өгүүлэн буй цаг хугацаа нь бүхэлдээ нэг намын ноёрхолд байсан учир ангилал бүрийн нэрний өмнө “part” буюу нам гэсэн гэсэн үгийг оруулсан. Одоо эдгээрийг тус бүрд нь авч үзье.

| | Ангилал | УТТ гишүүн | УТТ орлогч ⁵¹ | Нийт | |
|---|--------------|------------|--------------------------|------|-------|
| | | Тоо | Тоо | Тоо | Хувь |
| 1 | Партократууд | 14 | 6 | 20 | 45.45 |
| 2 | Парто- | 12 | 4 | 16 | 36.36 |

⁵⁰ УТТГ, орлогч гишүүнтэй давхардаагүй хиймсийг оруулсан.

⁵¹ Орлогч нарыг зөвхөн УТТГ-тэй давхардаагүй хиймсийг оруулсан.

| | | | | | |
|----------|-----------------------|----|----|----|-------|
| | технократ | | | | |
| 3 | Парто-демократ | 7 | 1 | 8 | 18.18 |
| 4 | Нийт | 33 | 11 | 44 | 100 |

Партократууд: УТТ гишүүн, орлогчоор ажиллаж байх хугацаанд ЕНБД, II НБД, НХШХ, УБ хотын намын хорооны дарга зэргийг хавсран гүйцэтгэж байсан хүмүүсийг партократууд гэсэн ангилалд оруулав. Эдгээр хүмүүс нь Б.Дамдин, Н.Лхамсүрэн, Д.Ламчин, Д.Моломжамц, Н.Жагварал, Д.Гомбожав, Б.Дэжид, Ц.Намсрай, Д.Төмөр-Очир, Б.Ламжав, П.Дамдин, Ю.Цэдэнбал⁵², Ж.Батмөнх, Н.Лувсанравдан, Ё.Магсар, С.Чойжамц, Б.Лхамсүрэн, С.Сосорбарам, Д.Самдан, Л.Лантуу нар бөгөөд УТТ-ны жинхэн гишүүн 14 гишүүн, орлогч 6 нийтдээ 20 хүн байгаа бөгөөд 45.45 хувийг эзэлж байна.

Парто-технократууд: УТТ гишүүн, орлогчоор ажиллаж байх хугацаанд СнЗ, ерөнхий сайд, орлогч зэрэг ЗГ-ийн албан тушаалыг хавсран гүйцэтгэж байсан хүмүүсийг парто-технократууд 34.8 хувьтай байна. Үүнд Ч.Сүрэнжав, Ц.Дүгэрсүрэн, Б.Ширэндэв, Л.Цэнд, С.Лувсан, Д.Майдар, Т.Рагчаа, Б.Жамбалдорж, Д.Доржпүрэв, Ж.Лхагвасүрэн, С.Балган, Ч.Аварзэд, С.Лувсангомбо, П.Жасрай, нарын УТТ-ны жинхэн гишүүн 11, орлогч 4 нийтдээ 16 хүнийг оруулав.

Парто - демократууд: УТТ гишүүн, орлогчоор ажиллаж байх хугацаанд хавсруулан УБХ, АИХ зэрэг хэлбэрийн төдий сонгуулийн байгууллагуудад АИХ-ын дарга, орлогч дарга зэрэг албан тушаалд ажиллаж байсан хүмүүс зүй ёсоор парто-демократууд гэсэн ангилалд орно. Ахмад партизан Г.Бумцэнд, С.Янжмаа, Д.Дамба, Ж.Самбуу, Б.Балжинням, С.Жалан-Аажав, Б.Алтангэрэл, Д.Цэдэв нарын УТТ-ны жинхэн гишүүн 7, орлогч 1 нийтдээ 8 хүн нь 18.18 орчим хувьд хүрнэ. Чухамдаа ингэж хавсран ажилласнаар тэдний эрх мэдэл улам бэхжиж, дарангуйлагч анги гэдэг дүр төрхөө улам бүр олдог байсан гэлтэй.

Судалгаанаас үзэхэд УТТ-ны гишүүд ба орлогчдын 54.5 орчим хувь нь төрийн албыг хавсруулан хашиж байжээ. Энэ баримт нь ноёрхогч нам бүхний тэргүүнд, хамгийн их эрх мэдэлтэй байсан гэдгийг төр бол намын шийдвэрийг хэрэгжүүлэгч механизм байсныг нотлон харуулж байна.

2. Элитүүдийн социал төрх

Судалгааны тухай товчхон. 1940-1990 он хүртэл УТТ-ны гишүүнээр МАХН-ын их хурлаас сонгогдсон 29 хүн, ТХ-ноос сонгогдсон 4 хүн нийтдээ 33 хүн, 11 орлогч гишүүнээр нийтдээ 44 хүн УТТ-ны гишүүнээр ажилласныг дээр дурдсан. Тэд бол социализмын үеийн дарангуйлагч тогтолцооны дээд элит хэсэг буюу удирдагчид мөн. Тиймээс бид нийтдээ 40 орчим хүнийг хамруулан нас, хүйс, мэргэжил, хувь хүний амьдралын түүх, ажиллаж байсан салбар, намд элссэн байдал, зэрэг нийгэм-эдийн засаг, амьдралын түүхийг бичиг баримт судлах контент анализын аргаар судалж дүгнэсэн. Ингэхдээ 20 орчим үзүүлэлтийг сонгон авч 100 орчим шкалтайгаар мэдээлэл цуглуулж нэгтгэн контент анализын аргаар судалсан ба математик, статистик боловсруулалт хийв. Мөн тухайн хүмүүсийн дурсамж бүтээл дээр тулгуурлан амьдралыг нь амьдралын түүхийн аргаар судалсан юм. Ингэхдээ энэ хүмүүсийн тухай материалыг нэгтгэн томоохон бүтээл туурвисан түүхч Ч.Болдбаатарын нөр их

⁵² Намын албан тушаал, Сайд нарын зөвлөл, АИХ гурав давхцах, аль алийг нь эрхэлж байсан тохиолдолд хамгийн эрх мэдэлтэйгээр нь 1-рт намын албан тушаал, дараа нь СнЗ-ын албан тушаал, эцэст нь АИХ-ын албан тушаал гэж эрэмбэлсэн болно. Тиймээс Ю.Цэдэнбал, Ж.Батмөнх нарыг партократ билэгт оруулсан.

хөдөлмөр, бүтээлийг зүй ёсоор дурьдах ёстой бөгөөд эл бүтээл энэ судалгааны ажлыг эхлүүлэхэд сэдэл болж өгсөн гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Мэдээж энэ бол УТТ-ны гишүүдийг нарийвчлан судлах эхний оролдлого төдий бөгөөд ташаарсан олон зүйл бийг дараа дараагийн судлаачид залруулан санал шүүмжлэлээ хайрлах нь лавтай юм.

а.Нас: Шинэ үеийн улс төрийн товчооны гишүүд хувьсгал, хэлмэгдүүлэлт, дайны дараах үеийн дүр төрхийг илэрхийлнэ. Судалгаанаас үзэхэд тэдний 34.2 хувь нь 1909-1914 оны хооронд төрсөн, 26.3 хувь нь 1915-1920 онд төрсөн, 1921-1950 оны хооронд 7.9 хувь нь төрсөн, 7.8 хувь нь 1925-1930 онд төржээ. Үлдсэн 18.4 хувь нь 1931-1945 оны хооронд төрсөн. Төрсөн оныг УТТ-ны гишүүн болсонтой харьцуулбал ихэнхи нь залуучууд байлаа. Товчоор хэлбэл, цаад тал нь 1909 онд Монголд эрх чөлөөний тэмцэл эхэлж байхад төрж эхлээд дийлэнх нь буюу 60 хувь нь 1909-1921 оны хооронд төржээ. Үлдсэн хэсэг нь 1921-1945 онд буюу үндэсний ардчилсан хувьсгалаас 2-р дайн хүртэлх хугацаанд эхээс мэндэлсэн. Дүгнэвэл, эрх чөлөөний хувьсгал, үндэсний ардчилсан хувьсгал, хэлмэгдүүлэлт, халх голын ба чөлөөлөх дайны дараа Монголын улс төрд цоо шинэ үеийнхэн гарч ирэх нөхцөл бүрдсэн юм. Хүйсийн хувьд Б.Янжмааг эс тооцвол эмэгтэй хүн алга. Шинэ ноёрхогч элитүүд бол Манжийн эрхшээл, тусгаар тогтнолын зурвас үе, Гамингийн түрэмгийлэл, Барон Унгерний дайралтыг мэдэхгүй. Тэр ч бүү хэл ихэнхи нь үндэсний эрх чөлөөний хувьсгалыг манлайлсан язгууртан, дээд лам нарыг хараагүй, хувьсгалчдыг ч сайн танихгүй юм. Чухамдаа түүхийн асар богинохон хугацаанд монгол орныг орвонгоор эргүүлсэн үйл явдлууд ар араасаа өрнөж байсан энэ хүнд бэрх үед тэд дөнгөж төрж байсан бөгөөд шат дараалуулан сургууль дамжиж номын мөр хөөж номенклатурчид болох бэлтгэлээ базааж байв. Тэд дараагийн 50 жилийн туршид Монголын улс төрийн тавцанд тоглох хувь тавилантай хүмүүс байжээ. Гэвч тэднийг олон хүнд хэцүү сорилт, бэрхшээл хүлээж байгаа.

б. Нутаг ус: Дэлхийн II дайны дараах шинэ цаг үеийн Монголын улс төрийн тоглогчид ямар нутгаас гаралтай вэ? Энэ маш сонирхолтой асуулт. Бид судалгаанд хамрагдсан УТТ гишүүн ба орлогч гишүүд дээр НБД гурван хүнийг нэмээд нийтдээ 47 хүний төрсөн нутгаар нь ангилан үзвэл дараах байдалтай байна.

| | Аймаг | Хүмүүсийн нэр | Тоо | Хувь |
|----|------------------|---|------------|-------------|
| 1 | Дорнод | Х.Чойбалсан, Б.Дамдин, Д.Майдар | 3 | 6.3 |
| 2 | Увс | Ю.Цэдэнбал, Ч.Сүрэнжав, Ж.Батмөнх, Т.Рагчаа, Б.Дэжид, П.Дамдин | 6 | 12.7 |
| 3 | Сэлэнгэ | Г.Бумцэнд, Н.Лхамсүрэн, Л.Цэнд, Н.Лувсанравдан | 4 | 8.5 |
| 4 | Булган | Д.Дамба, Ж.Лхагвасүрэн | 2 | 4.2 |
| 5 | Завхан | Ц.Дүгэрсүрэн, Б.Балжинням, С.Жалан-Аажав, С.Балган, Ц.Балхаажав | 5 | 10.6 |
| 6 | Төв | Ж.Самбуу, Б.Алтангэрэл, Д.Төмөр-Очир | 3 | 6.3 |
| 7 | Хөвсгөл | Б.Ширэндэв, Ц.Намсрай, С.Чойжамц | 3 | 6.3 |
| 8 | Дорноговь | Д.Ламчин, Н.Жагварал, С.Лувсан, Д.Содном, Б.Ламжав, С.Лувсангомбо | 6 | 12.7 |
| 9 | Дундговь | Д.Моломжамц, Б.Жамбалдорж, Д.Доржпүрэв | 3 | 6.3 |
| 10 | Ховд | Д.Гомбожав | 1 | 2.1 |
| 11 | Сүхбаатар | Ё.Магсар | 1 | 2.1 |
| 12 | Хэнтий | Б.Лхамсүрэн | 1 | 2.1 |

| | | | | |
|----|-------------|--|----|-----|
| 13 | Өвөрхангай | Д.Самдан, С.Сосорбарам | 2 | 4.2 |
| 14 | Говь-Алтай | Д.Цэдэв, Ч.Аварзэд, П.Жасрай, Л.Лантуу | 4 | 8.5 |
| 15 | Архангай | Д.Адьяа | 1 | 2.1 |
| 16 | Улаанбаатар | С.Янжмаа, М.Даш | 2 | 4.2 |
| | | Нийт | 47 | 100 |

Судалгаанаас үзэхэд тэдний 10.6 хувь нь Завхан аймгийнх, 12.7 хувь нь Дорноговийнх, 12.7 хувь нь Увсынх, 8.5 хувь нь Сэлэнгийнх, 8.5 хувь нь Говь-Алтайнх байна. Үлдсэн 6.3 хувь нь Хөвсгөлийнх, Төв аймгийнх 6.3 хувь, Дундговь 6.3 хувь, 4.2 хувь нь Өвөрхангайнх, 4.2 хувь нь Улаанбаатарынх, 4.2 хувь нь Булганыхан байна. Лавтайяа Увс ба Дорноговь аймгаас төрсөн хүмүүс бусдаасаа 2-6 дахин их байгаа нь анхаарал татаж байна. Энэ тухай Баабар өгүүлэхдээ:

Ширээнээсээ хальж ч болох байсан энэ айхавтар тэмцэлдээнд эцсийн бүлэгт түүнийг нутгийнхан нь авч гарлаа... Тэрээр УТТ-г тэн хагасыг нь өөрийн нутаг увсынхнаар дүүргэв. Нөгөө тал нь дорноговийн гэгдэх аж. Дорноговийнхон гэдэг нь харчин өвөр монголчууд байлаа (Баабар, 2005)

гэсэн юм. Бидий судалгаагаар ерөнхийдөө баруун аймгийнхан давамгайлах хандлага ажиглагдаж байна. Бусад аймгуудын хувьд бусдаасаа хамаагүй илүү биш харилцан тэнцвэртэй байжээ.

Ялангуяа Ю.Цэдэнбалын үед түүний дэвшүүлсэн хүмүүсийн дотор Увсынхан ба Дорноговийнхан давамгайлж байжээ. Түүнээс өмнө ингэж нутгархах хандлага харьцангүй бага байсан бололтой.

б. Бага, дунд боловсрол: Шинэ үеийн УТТ-ны гишүүдийн ихэнхи нь шаталсан боловсролын системийг дамжин сургуульд сурснаар үеийнхнээсээ ялгарч чадсан юм. Эхэн үед Монголд орчин үеийн стандартад нийцсэн бага, дунд сургууль төдийлөн байгаагүй атал нийт гишүүдийн 34.2 хувь нь бага сургууль төгссөн бол 42.1 хувь нь дунд сургууль төгссөн байна. Тиймээс 76.3 хувь нь бага, дунд сургууль төгссөн байгаа нь тухайн цаг үеийнхээ шаардлагатай харьцуулбал ихээхэн өндөр байгааг онцгойлон тэмдэглэх хэрэгтэй. Товчоор хэлбэл хуучны боловсролтой хүн хуруу дарам цөөхөн бөгөөд бүгд л шинэ цагийн сургууль соёлын мөрийг хөөсөн хүмүүс.

в. Мэргэжлийн сургалт, суурь дээд боловсрол: Шинэ үеийн элитүүдэд дунд сургууль дүүргэх нь хангалттай биш юм. Тийм ч учраас төрөл бүрийн мэргэжлийн сургуулийг төгсжээ. Тэр үед анх мэргэжилтэй боловсон хүчин үүсгэн байгуулах хэрэгцээ шаардлагын дагуу байгуулсан сургуулиуд тухайлбал Монголд худалдааны техникумыг 15.8 хувь нь төгссөн, Москвагийн КУТВ-ыг 18.4 хувь нь, Эрхүүгийн Монгол раффакийг 13.2 хувь нь, Монголын намын шинэ хүчний дээд сургуулийг 10.5 хувь нь төгсжээ. Мөн анхны их сургууль МУИС-ийг 5.3 хувь нь, Багшийн сургуулийг 7.9 хувь нь, Эдийн засгийн сургуулийг 5.3 хувь нь, ХААДС-ийг 2.6 хувь нь тус тус дүүргэжээ. Харин 7.8 хувь нь Москва, Ленинград хотуудад дээд сургууль төгссөн. Анхааралтай ажиглавал бараг тал хувь нь (5 хүн судалгаанд ороогүй) Орост, нөгөө тал нь Монголд суурь дээд боловсролыг эзэмшсэнээс харахад хувьсгалын дараа Монголын удирдагчдыг бэлтгэхэд Оросууд ихээхэн анхаарч байсныг харж болно. Тиймээс оросын нөлөө монголчуудад маш хүчтэй байсан нь дээрх ангиллаас ч гэсэн харж болно. Сонирхолтой нь тэдний дунд хувьсгалын дараа Герман, Франц зэрэг хөрөнгөтний орнуудад явуулсан олон хүүхдүүдээс нэг нь ч байхгүй.

г. Хоёр дахь дээд боловсрол: Социализмын үеийн улс төрийн товчооны гишүүдийн өөрсдөдөө тавих шаардлага маш өндөр байжээ. Судалгаанд хамрагдсан гишүүдийн 60 хувь нь дахин суралцсан гэдэг үзүүлэлт үүнийг нотлож байна. Мэдээж цаг үеийн хэрэгцээний дагуу хоёр дахь боловсрол нь ихэвчлэн улс төр, нийгмийн ухааны чиглэлийнх бөгөөд үүнд 5.8 хувь нь ЗХУ-д Намын дээд сургууль, 10.5 хувь нь МУИС-д, 21.2 хувь нь КУТВ-д суралцжээ. Мөн нийгмийн ухааны академи, аспирантурыг дүүргэсэн хүмүүс цөөн боловч бий. Дээрх баримтуудаас УТТ-ны гишүүдийн суралцахдаа зарцуулсан хугацааг гаргавал 23.7 хувь нь 4-9 жил, 28.9 хувь нь 10-15 жил, 31.6 хувь нь 16-20 жилийг суралцахад зарцуулсан байна. Харин 2.6 хувь нь 20-оос дээш жил суралцсан. Ингэж сургуульд сурах нь хувь хүний амьдралыг өөрчлөх нийгмийн социал статусаа дээшлүүлэх асар их боломжид тооцогдож байв. Тийм ч учраас цоо шинэ шалгуураар шинэ хүмүүсийг гаргаж ирэх бололцоог бий болгосноороо социализм нь хуучин засгаас үлэмж дэвшилттэйд тооцогдоно.

Гэхдээ сургуульд сурах хүүхдүүдэд гэсэн цаг үеийнхээ шаардлагаар цензур тавьж байсан гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Ингэж шинээр сургууль төгссөн хүмүүс төрд асар их эрэлт хэрэгцээтэй байв. Тэр тусмаа хамгийн анхны Орост төгсөгчдөөс олон хүнийг шууд удирдах албан тушаалд томилж байлаа.

д. Мэргэжил: Шинэ цагийн элитүүд ямар мэргэжилтэй байв? Эдийн засагчид толгой цохиж байна. Тэдний 3 хүн тутмын нэг нь эдийн засагч, 18.4 хувь нь багш, 10.6 хувь нь нийгмийн ухааны мэргэжилтэй, 7.9 хувь нь эмч, 5.3 хувь нь инженер, мөн 5.3 агрономич мэргэжилтэй байна. Ихэнхи нь тухайн салбартаа хамгийн анхны мэргэжилтнүүд байв.

1921 оны хувьсгалын дараа төр засгаа төвхнүүлэх нэн хариуцлагатай ажил зүй ёсоор хувьсгалчдад оногджээ. Үүнд тохиромжтой боловсон хүчин байхгүй байв. Тиймээс тэд хувьсгалч журамт цэргүүд дотроос эхний ээлжинд хүмүүс шалгаруулсан, мөн олон хүнийг сургуульд сургах байдлаар бэлтгэж эхэлжээ. Гэвч хувьсгалчид туршлагагүй, хангалттай боловсон хүчний нөөцгүй байсан явдал нь өмнөх үеийн түшмэдийн олноор нь хэрэглэхэд хүргэсэн.

е. Салбарын карьер: Боловсролын ба ХАА-н салбараас албан тушаал илүүтэй хурдан өгсөх нь харагдана. Мөн орон нутгийн болон МХЗЭ зэрэг олон нийтийн ажил цөөнгүй хүнд гарааны цэг болж байв. Нийт гишүүдийн 28.9 хувь нь боловсролын салбараас төрсөн байхад ХАА-н салбараас төрөгсөд 15.8 хувьтай байв. Үлдсэн хэсэг буюу армиас 7.9 хувь нь, худалдааны салбараас 7.9 нь, татвар, Сангийн яам, статистикийн алба, Улсын төлөвлөгөөний газраас 15.8 хувь нь төржээ.

ё. Намын гишүүнчлэл: Ямар ч нийгэмд албан тушаал өгсөхөд хамгийн чухал зүйл бол намд элсэх явдал юм. Яг үнэндээ боловсролын төвшин, нарийн мэргэжлээс гадна намын гишүүнчлэл нь үндсэн шалгуур байв. Тиймээс ч тэд харьцангуй залуудаа намд элссэн байна. Гишүүдийн 21.1 хувь нь 19-24 насандаа, 34.2 хувь 25-29 насандаа, 18.4 хувь нь 30-34 насандаа МАХН-д элсжээ. Дүгнэвэл 29 хүртэлх насандаа элссэн хүмүүс талаас илүү нь болж байна. Тийм ч учраас тэдний 34.2 хувь нь 19-24 насандаа удирдах албанд, 44.7 хувь нь 25-29 насандаа удирдах албанд, 15.8 хувь нь 35-аас дээш насандаа удирдах албанд очсон байна.

3. Элитийн сэлбэлт, өгсөлт ба уруудалт.

а. Улс төрийн товчооноос огцорсон нь. Хэдэн насандаа УТТ гишүүн болов? Улс орны хамгийн дээд удирдлагын төвшинд гарч ирэхдээ тэд хэдэн настай байсан гэсэн асуулт нэн сонирхолтой. Судалгаанаас харахад тэдний 28.9 хувь нь 30-37 настайдаа, 13.2 хувь нь 38-42 насандаа, 21.1 хувь нь 43-50

насандаа, 23.7 хувь нь 51-58 насандаа УТТ-ны гишүүн болжээ. Хоёрхон хүн буюу 5.3 хувь нь л тэтгэвэрт гарах дөхсөн үедээ 59-66 насандаа сонгогджээ. Дээрх баримтаас харахад социализмын өрнүүн бүтээн байгуулалтын үед Монголыг залуучууд л хөтөлж оруулсан байна. Ингэж тэд маш хурдан засгийн эрхийг авсан ч өөрсдөө дараагийн үедээ байраа тавьж өгөх дээр тун ч хойрго хандаж байлаа. Тэд удирдагчтай муудалцаж, итгэлийг нь даахаа болиогүй л бол суудал дээрээ өтөлж байв. Улс төрийн товчооноос огцрох шалтгаан юу вэ? УТТ-ын гишүүд асар их эрх мэдэлтэй байв. Тэд их хурлаас, мөн их хурлуудын хоорондох ТХ-ны бүгд хурлаас ахин дахин сонгогдож байв.

б. Огцрох болдог шалтгаан юу вэ? УТТ-ны гишүүнээс огцрох болох хамгийн гол шалтгаан нь Цэдэнбалын эсрэг байр суурьтай, үзэл бодлоор тэнцэхгүй гэсэн шалтгаан юм. Тийм ч учраас тэдний 15.8 хувь нь 30-37-хон насандаа, 26.3 хувь нь 38-42 насандаа огцорсон. Мөн огцрохдоо 13.2 хувь нь өөрийн хүсэлтээр (мэдээж цаана нь өөр шалтгаан бий), 2.6 хувь нь тэтгэвэрт, 2.6 хувь нь эрүүл мэндийн гэсэн бодитой шалтгаанаар халагдаж байв. Ямар боловч бараг 4 хүн тутмын нэг нь Цэдэнбалтай зөрчилдсөнөөс болсон гэсэн баримт байна. Түүвэрлээд үзэхүл хугацаанаасаа өмнө огцорсон УТТ-ны гишүүд байна.

| | Сонгогдсон их хурал/ТХ-ны БХ | УТТ гишүүн, орлогчоор сонгогдсон боловч бүрэн эрхийн хугацаагаа янз бүрийн шалтгаанаар гүйцээгээгүй хүмүүс | Жин хэнэ | Орлогч | Нийт |
|---|--|---|----------|--------|-------|
| 1 | 1940-3-р сарын 20. Х их хурал | УТТ-ны гишүүн Д.Доржпүрэв (1941), Ж.Лхагвасүрэн (1943-12-р), УТТ-ны орлогч гишүүн Ё.Магсар (1940-7), | 2 хүн | 1 хүн | 3 хүн |
| 2 | 1943- 12-р сард Тэргүүлэгчдийг УТТ болгон өөрчлөн з/б. ТХ-ны бүгд хурал | УТТ-ны орлогч гишүүн Ж.Лхагвасүрэн (1947-12) | -- | 1 хүн | 1 хүн |
| 3 | 1947-12-2-23. XI их хурал | УТТ-ны гишүүн Г.Бумцэнд (1952), Ч.Сүрэнжав (1954), Х.Чойбалсан (1952 онд нас барав), С.Янжмаа (1949-6) УТТ-ны орлогч гишүүн С.Чойжамц (1950-7-р сар), | 4 хүн | 1 хүн | 5 хүн |
| 4 | 1954-4-р сард ТХ-ны IV | УТТ-ны орлогч гишүүн Д.Цэдэв (1956--) | -- | 1 хүн | 1 хүн |
| 5 | 1954-11-19-24. XII их хурал | УТТ-ны гишүүн Ц.Дүгэрсүрэн (1956), Н.Лхамсүрэн (1956), Б.Ширэндэв (1956), | 3 хүн | -- | 3 хүн |
| 6 | 1956- ТХ-ны IV | УТТ-ны орлогч гишүүн Ц.Дүгэрсүрэн (Удалгүй огцров.) | -- | 1 хүн | 1 хүн |
| 7 | 1957-7-р сард УТТ гишүүн 7-8, орлогчийг 3-5 болгон нэмэгдүүлэв. ТХ-ны VI | УТТ-ны орлогч гишүүн Ч.Аварзэд , (1958) | -- | 1 хүн | 1 хүн |
| 8 | 1958-3-17. XIII их хурал | УТТ-ны гишүүн Д.Дамба (1959-3 сар), Б.Дамдин (1959-3 сар), Д.Ламчин (1959-3), Ч.Сүрэнжав (1959-3), Л.Цэнд (1963-12-р), УТТ-ны орлогч гишүүн С.Балган (1959), Д.Самдан (1959-3 сар), | 5 хүн | 2 хүн | 7 хүн |
| 9 | 1959-3-р сард УТТ-ны 14 гишүүнээс 5-г огцруулж 7/2 болов. ТХ-ны III | УТТ-ны гишүүн Д.Төмөр-Очир (1960-7 сар) | 1 хүн | -- | 1 хүн |
| 1 | 1961-7-3-7. XIV | УТТ-ны гишүүн Д.Балжинням (1962), Цэнд , | 2 хүн | -- | 2 хүн |

ПОЛИТОЛОГИ IV
Эрдэм шинжилгээний бичиг № 297 (50)

| | | | | | |
|--------|------------------------------|--|-------|-------|-------|
| 0 | их хурал | | | | |
| 1 1 | 1962-2 сард ТХ-ны II | УТТ-ны гишүүн Д.Төмөр-Очир (1962 ТХ-ны 3-р хурал) | -- | 1 хүн | 1 хүн |
| 1 2 | 1971-7-11. XVI их хурал | УТТ-ны гишүүн Ц.Дүгэрсүрэн (1971-11 сар), С.Лувсан (1976), Ж.Самбуу (1972 онд нас барав.), УТТ-ны орлогч гишүүн Б.Лхамсүрэн (1972) | 3 хүн | 1 хүн | 4 хүн |
| 1 3 | 1976-6-14-18. XVII их хурал | УТТ-ны гишүүн Н.Жагварал (1981-5 с), Н.Лувсанравдан (1981), | 2 хүн | -- | 2 хүн |
| 1 4 | 1981-5-26-30. XVIII их хурал | УТТ-ны гишүүн Д.Гомбожав (1985), С.Жалан-Аажав (1983-12), Д.Майдар (1984-12), Ю.Цэдэнбал (1984-8), | 4 хүн | -- | 4 хүн |
| 1 5 | 1986 XIX их хурал | УТТ-ны гишүүн Б.Алтангэрэл (1990-3), Ж.Батмөнх (1990-3), Б.Дэжид (1990-3), Д.Моломжамц (1989-12), Ц.Намсрай (1990-3), Т.Рагчаа (1987-6), Д.Содном (1990-3), | 7 хүн | -- | 7 хүн |
| 1 6 | 1987-6 сард ТХ-ны ? | УТТ-ны гишүүн Б.Ламжав (1989) | 1 хүн | -- | 1 хүн |
| 1 7 | 1989-12 сард ТХ-ны VII | УТТ-ны гишүүн П.Дамдин (1990-3) УТТ-ны орлогч гишүүн П.Жасрай (1990-3), Л.Лантуу (1990-3) | 1 хүн | 2 хүн | 3 хүн |
| 1 8 | | Нийт давхардсан тоогоор | 35 | 12 | 47 |
| 1 9 | | Дан тоогоор /Годруулсан нэрнүүд давхардаагүй нэрс/ | 31 | 9 | 42 |

Бид УТТ-ны гишүүн, орлогчдыг дараах 4 үндсэн бүлэгт хуваан үзсэн болно.

| | Ангилал | УТТ гишүүн | | УТТ орлогч гишүүн ⁵³ | | Нийт | |
|---|------------------|------------|-------|---------------------------------|-------|------|-------|
| | | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| 1 | Нас барах | 3 | 9.09 | 0 | 00 | 3 | 6.8 |
| 2 | Хэлмэгдэх | 11 | 33.33 | 5 | 45.45 | 16 | 36.36 |
| 3 | Шахагдах | 13 | 39.39 | 4 | 36.36 | 17 | 38.6 |
| 4 | Системийн сүйрэх | 6 | 18.18 | 2 | 18.18 | 8 | 18.18 |
| | Нийт | 33 | 100 | 11 | 100 | 44 | 100 |

Нэгдүгээрт. Насныхаа эцэст УТТ гишүүнээр ажиллаж байгаад улмаар бие эцэслэсэн хүмүүсийг энэ бүлэгт оруулсан. Энэ хүмүүс хэлмэгдэх, шахагдах, систем сүйрэхийг үзээгүй нас бартлаа албан тушаалдаа ажиллаж байсан хүмүүс юм. Үүнд Х.Чойбалсан, Г.Бумцэнд, Ж.Самбуу нарыг оруулж болно. Тэдний дунд УТТ-ны орлогч гишүүн байхгүй.

Хоёрдугаарт. УТТ-ны жинхэн болон орлогч гишүүн гэсэн өндөр албан тушаалаас огцорч хэлмэгдэж ажил амьдралаараа хохирсон хүмүүсийг энэ ангилалд багтаав. Ялангуяа Ю.Цэдэнбалыг өөрийг нь болон түүний эсрэг тодорхой хэмжээний тэмцэл хийгээд ялагдсан хүмүүсийг энэ бүлэгт оруулав. Тухайлбал Ё.Магсар “хувьсгалын эсэргүү-хэлмэгдүүлэлт”, П.Доржпүрэв “Баасанжавын бүлэг-хэлмэгдүүлэлт”, Ч.Аварзэд “зөвлөлтийн эсрэг үзэлтэн-хэлмэгдүүлэлт”, Ю.Цэдэнбал “хуйвалдаан-гэрийн хорионд”, С.Янжмаа “намч бус явдал”, Д.Дамбын “намын эсрэг бүлэг” Б.Дамдин, С.Балган, Д.Ламчин нарын “Дамбын бүлэг-огцролт”, Д.Самдан “Дамбын бүлэг, ажилд тэнцэхгүй-огцролт”, Н.Лхамсүрэнг “Дамбын бүлэг” “Намын эсрэг бүлгийн сүлбээтэн” хэмээн, Б.Ширэндэвийг “сайн дурын хүсэлт-огцролт”, Д.Цэндийн “намч бус ажил

⁵³ УТТ-ны орлогч гишүүдийг тооцоходоо УТТ-ны орлогч гишүүн байж байгаад УТТ-ын гишүүн болсон хүмүүсийг оруулаагүй, зөвхөн УТТ-ны орлогч гишүүн хийсэн хүмүүсийг л оруулав. Харин УТТ-ын орлогч гишүүн байж байгаад УТТ-ны гишүүн болсон хүмүүсийг УТТ-ны гишүүн гэсэн ангилалд оруулж тооцсон болно.

явууллага-хэлмэгдүүлэлт”, С.Жалан-Аажавын “тэтгэвэр-намын эсрэг бүлэг-хэлмэгдүүлэлт”, Д.Төмөр-Очир “намын эсрэг бүлэг-хэлмэгдүүлэлт”, Б.Лхамсүрэн “Ширэндэвийг өмөөрсөн-огцролт” зэргээр 16 хүн буюу нийт УТТ-ны гишүүн орлогчийн 36.36 хувь нь хэлмэгдсэн юм. Тэдэнтэй хамт монголын олон эх оронч сэхээтнүүд хэлмэгдэж зовсон билээ. Хамгийн их олноороо огцордог байсан он жилүүд нь 1958-1966 он бөгөөд 8 хүн огцорсон нь хамгийн өндөр, 1976-1984 онд 4 хүн тус тус огцорч байв. Мэдээж олноороо огцордог байсан тохиолдол нь Ю.Цэдэнбал засгийн эрхийг дангаараа эзэмшихийн төлөө тэмцэж өрсөлдөгч нараа хэлмэгдүүлж байсантай давхцана. Бүлгүүдийг харьцуулж үзвэл УТТ-ны орлогч нар хэлмэгдэлд илүүтэй өртдөг байсан гэдэг нь харагдаж байна.

Гуравдугаарт. Хоцрогдсон, ажлын алдаа гаргасан, мөн Цэдэнбалын дэглэмийн үед түүнд таалагдахаа больсон, үнэнч бус гэж бодсон хүмүүсийг албан тушаалаас нь огцруулдаг байв. Гэхдээ ингэж албан тушаал буух нь хэлмэгдэхээс асар их ялгаатай юм. Тухайлбал Ж.Лхагвасүрэнг “академид суралцуулна”, Ч.Сүрэнжавыг “хоцрогдсон” хэмээн Х.Нямбуу, Д.Төмөр-Очир нарын шаардлагаар огцруулсан бол Ц.Дүгэрсүрэнг “ажлын алдаа” гаргасан, С.Чойжамцыг “сургуульд сурах”, Д.Цэдэвийг “ДЯЯ-ны сайд байхдаа хэлмэгдүүлэлт хийсэн-огцролт”, Б.Жамбалдоржийг “хэлмэгдүүлэлт явуулсан”, Д.Балжиннямыг “тодорхой үндэслэлгүй огцруулсан”, Д.Моломжамцыг “чөлөөлөгдөх хүсэлт гаргасан”, С.Сосорбарамыг “эрүүл мэндийн байдал, өөрийн хүсэлт-огцролт”, Н.Жагваралыг “Горбачевтай зөрөлдсөн”, С.Лувсанг “тэтгэвэрт”, Н.Лувсанравданг “Цэдэнбалын санаачлагаар”, Т.Рагчааг “огцруулсан”, Ц.Майдарыг “Цэдэнбалын бүлэг”, Д.Гомбожавыг “тэтгэвэрт”, Б.Ламжавын “огцролт”, С.Лувсангомбыг “сайн дурын хүсэлт-тэтгэвэр” зэрэг шалтгаанууд нь нийлээд 17 буюу 38.6 болж байна. Амьдралын түүхийн судалгаанд хамрагдагсадын 13.2 хувь нь аймагт нарийн бичгийн даргын албан тушаал хашдаг, 13.2 хувь нь элчин сайд, 13.2 хувь сургуулийн захирал, 5.3 хувь нь САА-д ажилладаг ажээ. Ганц нэгхэн тохиолдолд огцроод шууд тэтгэвэртээ гардаг байна.

Дөрөвдүгээрт. 1990 онд социалист систем нуран унаж Ж.Батмөнх, Б.Алтангэрэл, Б.Дэжид, Ц.Намсрай, П.Дамдин, Б.Ламжав, П.Жасрай, Л.Лантуу нарын 8 гишүүнтэй УТТ бүрэн бүрэлдхүүнээрээ 1990 оны 3-р сард огцорчээ. Судалгаанд хамрагдагсадын 18.8 хувь нь болж байна. Мэдээж ингэснээрээ П.Жасрайг эс тооцвол тэдний улс төрийн амьдрал бүхэлдээ төгсгөл болсон билээ.

Улс төрийн товчооны жинхэн гишүүдийн 25 хувь нь буюу дөрөвний нэг нь 4-ба түүнээс дээш удаа буюу 16-44 жилийн хугацаанд тасралтгүй, удаан хугацаагаар үргэлжлүүлэн, давтан сонгогдож байв. Өгүүлэн буй хугацаанд УТТ гишүүний 74 хүний орон тоон дээр их хурал ба ТХ-ны бүгд хурлаас давхардаагүй байдлаар 43 хүнийг ажиллуулжээ. Энэ нь нэг хүний улиран сонгогдох байдал 1.7 хувьтай байгааг харуулах бөгөөд үүнийг хурлуудын хоорондох 5.5 жилээр үржүүлвэл нийтдээ 9.4 жил болно. Өөрөөр хэлбэл нэг УТТ гишүүн дунджаар 2 удаа сонгогддог, дунджаар 9.4 жил ажилладаг нь сонирхолтой баримт юм. Үүнээс үзэхэд монголын улс төрийн лидерүүдийн улс төрийн оргил нас 10 орчим жил болов уу гэсэн таамаглалыг дэвшүүлэхэд хүргэж байна. Энэ нь нэг талаас хүний амьдралаар нэгэн эргэлт буюу 12 жилтэй таарч байгаа бол нөгөө талаас гурван сонгуулийн хугацаа юм. Мөн онолын ном зохиолд улс төрийн насыг 10-14 жил хэмээн бичдэгтэй таарч байна.

Судалгаанаас харахад УТТ-ны гишүүд бараг зуун хувь намын, Засгийн газрын, эсвэл Төрийн удирдах албан тушаалыг хавсардаг байжээ. Үүнд УТТ

гишүүн болохоос өмнө ба огцорсны дараа дээрх албан тушаалыг хашиж байсныг оруулаагүй гэдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй болов уу⁵⁴. Мөн албан тушаал хаших хугацаа нь уртсах тусам эрх мэдэл илүүтэй төвлөрүүлэх хандлага их байна. Ингэж албан тушаалыг ээлжилж, хавсруулж, төвлөрүүлж удаан хугацаагаар хаших явдал түгээмэл байсан нь эрх мэдлийн хуваарьгүй эзэмшигч ноёрхогч элит нь бүрэн хаалттай систем байсныг харуулна.

1981 онд сонгогдсон 8 гишүүдээс хоёр нь Цэдэнбалын явуулгаар огцорсон. Харин түүнийг өөрийг нь огцруулсны дараа дөнгөж хоёр л хүнийг УТТ гишүүнээс огцруулсан бөгөөд үлдсэн хэсэг нь 1986 оны их хурлаас дахин сонгогдсон байна, энэ баримт нь Ю.Цэдэнбал огцорсон ч 1990 он хүртэл монголын улс төрийн дарангуйлагч дэглэм огтхон ч өөрчлөлт ороогүй хэвийн ажиллаж байсныг харуулах бөгөөд тоталитар дэглэм нь авторитар дэглэмээс ялгаатай нь удирдагч нь солигдоход огтхон ч өөрчлөлт ордоггүй гэдгийг нотлож байна. 1954 оноос авторитар дэглэмийн хууль эрх зүйн үндэс намын дүрмээр үүсч 1966 оноос авторитар дэглэм бодитой тогтжээ. Тиймээс монгол улсад 1940-1990 оны хооронд тоталитари дэглэм үүсч бүрэлдэж оршин тогтнож байсныг батлан харуулж байна.

Ашигласан ном, бүтээл

1. C.W., M. (1956). *The power Elite*. Oxford
2. Linz J. J. (2000). *Totalitarian and Authoritarian regimes*
3. А. Юндэндорж. (2000). *Особенности политической системы Монголии в условиях перехода к конституционализму*. УБ
4. С.Баабар. (2005). *Монголчууд. Нүүдэл суудал*. УБ: Соёмбо принтинг
5. С.Баатар. (2005). *Эх орончид ба Цэдэнбал*. УБ: Ган принт
6. Ж.Болдбаатар. (2004). *Түүх зулсан он жилүүдийн ойллого*. УБ
7. Ч.Болдбаатар. (2004). *XX зууны Монголын улс төрийн зүтгэлтнүүд*. УБ: Адмон
8. Ж.Болдбаатар. М. Д. (1985). *МАХН-ын үйл ажиллагаанд намын их хурал, Төв хорооны бүгд хурлуудын роль*. УБ: Улсын хэвлэлийн газар
9. Д.Ганбат. (2007). *XX зууны ардчиллын хөгжил ба Монгол улс. Шинэ толь*, 5-17
10. Ц.Ганболд. (1997). *Монгол дахь улс төрийн модернизацийн зарим онцлог. Эрдэм шинжилгээний бичиг*, 44-48
11. А.Гидденс. (2006). *Социологи*. УБ: Адмон
12. Х.Гүндсамбуу. (2002). *XX зуун Монголын нийгмийн давхраажил хөгжил хандлага*. УБ
13. Ж.Болдбаатар., Ч.Дашдаваа. (2005). *Шинэчлэлийн төлөө хөдөлгөөн, түүний хувь заяа*. УБ
14. О.Крыштановская. (2004). *Анатомия Российской Элиты*. Москва
15. *МАХН-ын Онц их хурлын материал*. (1992). УБ: Улсын хэвлэлийн газар
16. *МАХН-ын Төв хорооны VIII бүгд хурлын материал*. (1990). УБ: Улсын хэвлэлийн газар
17. *Монгол ардын хувьсгалт намын түүхэн замнал*. (1995). УБ
18. Ч.Өлзийсайхан. (2003). *Монгол дахь улс төрийн элитийн хэв маягийн өөрчлөлт, төлөвшилтийн зарим асуудал. Социологи*, 69-72